



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/199

Булган сум

**Соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 35 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны дагалдах арга хэмжээ болох соёл урлагийн тоглолтыг бүс, орон нутгийн түүх, өв соёл, угсаатан, ястны онцлогийг харуулсан байхаар төлөвлөж, удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:

А.Наранболд (Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Д.Цэцэгмаа (Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

А.Уранчимэг (Орхон аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Л.Батцэцэг (Хөвсгөл аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)

Х.Хишигбаатар (Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театрын дарга)

Ж.Даваадамдин (Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

Д.Ганцогт (Хөгжимт жүжгийн театрын ерөнхий найруулагч)

Е.Баярмагнай (Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театрын найруулагч)

О.Гэрэлт-Од Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театрын найруулагч)

Б.Доржжанцан (Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын ерөнхий найруулагч)


Нарийн бичгийн дарга:Г.Алдармөнх (Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

6325010299


2.Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг дагалдан зохион байгуулагдах соёл урлагийн арга хэмжээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.“Соёл урлагийн арга хэмжээ”-ний төлөвлөгөөг боловсруулж, мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke, positioned over the printed name.

Д.ПҮРЭВ-ОЧИР



**БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН ӨРГӨТГӨСӨН ХУРАЛДААНЫГ ДАГАЛДАН ЗОХИОН
БАЙГУУЛАГДАХ СОЁЛ УРЛАГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Нэг: Зорилго

Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны ач холбогдлыг тодотгох, бүсийн бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжин хөгжүүлэх, бүс, орон нутгийн түүх соёл, угсаатан, ястны онцлогийг үндэстэн төдийгүй олон улсад сурталчлан таниулах

Хоёр: Арга хэмжээ болох байршил, хамрах хүрээ

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр “Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”-ыг бүсийн аймгуудын үсгийн дарааллаар жил бүр ээлжлэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Уг хуралдаан 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт зохион байгуулагдах бөгөөд соёл урлагийн арга хэмжээ дагалдан зохион байгуулагдана.

2.2. Соёл урлагийн арга хэмжээнд аймаг, хойд бүсийн сумдад төрсөн болон амьдарч байгаа уран бүтээлчид, урлаг соёлын алдартнууд, ардын авьяастнуудын төлөөлөл, хамтран оролцоно.

Гурав: Зохион байгуулагдах арга хэмжээ

- 3.1. Мэргэжлийн урлагийн байгууллагын хамтарсан тоглолт
- 3.2. Бүсийн аймгуудын туг залах ёслол, бүсийн даргыг батламжлах үе
- 3.3. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны нээлтийн үе
- 3.4. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны хаалтын үе
- 3.5. Хүндэтгэлийн хүлээн авалт, оройн зоог барих үе
- 3.6. Талбайн арга хэмжээ /аймаг тус бүр/

Дөрөв: Тавигдах шаардлага

- 4.1. Мэргэжлийн ур чадвар харуулсан найруулга, өвөрмөц зохиомжтой байх
- 4.2. Бүсийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан байх;
- 4.3. Арга хэмжээ бүхэлдээ өөрийн гэсэн дүр төрх, өнгө аястай байх
- 4.4. Бүсийн аймгуудад шилжин зохион байгуулагдах агуулга бүхий залгамж халаа, уялдаа холбоог урьдчилан төлөвлөсөн байх
- 4.5. Бүс нутгийн угсаатан, ястны онцлогийг тодотгон харуулсан байх;
- 4.6. Бүсийн аймгуудын оролцоог жигд хангасан байх;
- 4.7. Үндэсний болон орчин үеийн хөгжим, техник, тоног төхөөрөмж хослуулсан байх;
- 4.8. Бүх насны ангилалд хүртээмжтэй, сонирхол татахуйц, энтэртаймэнт байх;
- 4.9. Төгсгөл хэсэг хүлээлт үүсгэхүйц, дараагийн аймагт шилжиж буй тавилттай байх;